



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.13 № 347

танай _____ -ы № _____ -т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН Г
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
А.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу танай байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг 1 албан шаардлага, 1 төлбөрийн актын хамт хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Хавсралт  хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

 Ж.ГАНБААТАР

232530347

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2025/157/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Audit.mn
Хэнтий аймаг
Чингис хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан
Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396

Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 216

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасаг нь хэвлэмэл хуудас хэвлэх үйлчилгээг нэвтрүүлснээр өөрийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх боломж бүрдүүлж, мөн нэг цэгийн үйлчилгээний танхимын засвар, автомашины зогсоол, хоёр тээврийн хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс батлагдсан 600,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 597,400.0 мянган төгрөгийг зарцуулсан нь санхүүгийн тайланд голлох нөлөө үзүүлж, үүнээс иргэд, байгууллагын хүсэлт шийдвэрлэхэд 24%, хууль, шийдвэр хэрэгжүүлэхэд 4.5%, нэг удаагийн арга хэмжээнд 28%, гамшгийн хохирол арилгах

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
А.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

зардалд 24%, шагнал урамшуулал, буцалтгүй тэтгэмжид 19.5%-ийг тус тус зарцуулсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын дансанд бүртгэлтэй 48,945.0 мянган төгрөгийн үнэ бүхий мал, амьтдын бүртгэл, хяналт хангалтгүй байгаагаас мэдээллийн зөрүү үүсэх, өмчийн удирдлагад эрсдэл нэмэгдэх нөхцөл бүрдэж болзошгүй тул анхан шатны баримтад үндэслэн тооллого, тооцоог тогтмол хийж, үр дүнг данс бүртгэлд тухай бүр тусган ажиллах шаардлагатай.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	522,376,507.80	481,401,752.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	111,550.00	4,970,550.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	111,550.00	4,970,550.00
3121	Төгрөг	111,550.00	4,970,550.00
31211	Төрийн сангийн харилцах	111,550.00	4,954,550.00
31213	Арилжааны банк дахь харилцах	-	16,000.00
33	АВЛАГА	35,247,677.00	2,633,653.40
335	Бусад авлага	35,247,677.00	2,633,653.40
3351	Байгууллагаас авах авлага	32,747,677.00	133,653.40
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,500,000.00	2,500,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	487,017,280.80	473,797,548.60
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	427,137,280.80	424,852,548.60
35410	Бичиг хэргийн материал	6,352,500.00	1,015,000.00
35420	Аж ахуйн материал	377,719,290.80	389,901,058.60
35430	Сэлбэг хэрэгсэл	38,885,490.00	15,936,490.00
35440	Түлш, шатах тослох материал	4,180,000.00	18,000,000.00
35600	Мал амьтад	59,880,000.00	48,945,000.00
2	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	3,482,879,804.73	4,268,521,566.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,482,879,804.73	4,268,521,566.27
392	Биет хөрөнгө	3,119,638,138.17	3,968,469,899.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,908,689,984.00	3,441,659,867.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(382,854,735.80)	(486,758,990.71)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	420,500,773.24	634,395,217.84
39204	Хуримтлагдсан элэгдэл	(351,573,570.46)	(385,832,913.89)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	974,560,919.51	953,498,598.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	(611,783,403.06)	(658,252,832.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	400,370,360.57	364,092,065.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	(330,367,434.45)	(301,697,247.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	259,297,273.00	606,106,383.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(167,202,028.38)	(198,740,246.80)
393	Биет бүс хөрөнгө	363,241,666.56	300,051,666.64
39301	Програм хангамж	48,322,000.00	47,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(36,905,333.44)	(44,673,333.36)
39303	Бусад биет бүс хөрөнгө	351,825,000.00	296,825,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,005,256,312.53	4,749,923,318.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,005,256,312.53	4,749,923,318.27
51	Засгийн газрын хувь оролцоо	4,005,256,312.53	4,749,923,318.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,485,687,328.00	1,485,687,328.00
51101	Өмч: - төрийн	1,230,487,328.00	1,230,487,328.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	255,200,000.00	255,200,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,395,033,788.38	2,139,700,794.12
51210	Өмнөх үеийн үр дүн	1,395,033,788.38	1,395,033,788.38
51220	Тайлант үеийн үр дүн	-	744,667,005.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,124,535,196.15	1,124,535,196.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,005,256,312.53	4,749,923,318.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,678,871,588.30	6,188,642,547.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	364,621,765.30	1,148,115,519.60
120	Нийтлэг татварын бус орлого	364,621,765.30	1,148,115,519.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	364,621,765.30	1,148,115,519.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,717,975.00	40,623,769.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	336,903,790.30	1,107,491,750.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,314,249,823.00	5,040,527,028.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,001,930,023.00	347,010,728.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	439,303,212.00	93,239,783.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	562,626,811.00	253,770,945.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,312,319,800.00	4,693,494,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,312,319,800.00	4,693,494,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	22,000.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	22,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,745,591,561.28	5,443,975,541.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,745,591,561.28	5,443,975,541.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,327,038,746.27	4,928,103,351.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,616,886,571.96	2,396,180,025.57
210101	Үндсэн цалин	873,974,569.01	1,106,962,761.71
210102	Нэмэгдэл	447,642,269.35	941,217,132.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,973,000.00	106,388,231.73
210104	Урамшуулал	202,239,155.73	122,093,306.44
210105	Гэрээт ажлын хөлс	24,057,577.87	119,518,593.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	236,357,495.55	285,824,970.41
210201	Тэтгэврийн даатгал	135,322,917.57	193,345,243.84
210202	Тэтгэмжийн даатгал	15,899,201.79	22,984,163.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	50,808,885.74	12,465,862.90
210204	Ажилгүйдлийн даатгал	3,071,973.10	9,998,671.90
210205	Эрүүл мэндийн даатгал	31,254,517.35	47,031,027.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,576,883.44	202,204,784.32
210301	Гэрэл, цахилгаан	30,972,970.94	36,494,945.31
210302	Түлш, халаалт	133,844,576.50	153,885,061.00
210303	Цэвэр, бохир ус	3,559,336.00	6,124,778.01
210304	Байрны түрээс	34,200,000.00	5,700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	136,189,782.95	194,602,716.10
210401	Бичиг хэрэг	23,914,800.00	34,485,500.00
210402	Тээвэр, шатахуун	71,448,537.00	90,336,578.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,545,197.95	21,145,491.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	610,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,671,248.00	48,095,147.00
2105	Нормативт зардал	3,493,781.00	1,608,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,493,781.00	1,608,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	158,624,130.00	162,099,366.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	8,341,600.00
210604	Урсгал засвар	158,624,130.00	153,757,766.20
2107	Томилолт, зочны зардал	81,487,832.00	132,274,679.00
210701	Гадаад албан томилолт	15,530,040.00	2,849,280.00
210702	Дотоод албан томилолт	64,540,800.00	123,187,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,416,992.00	6,237,799.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,684,836.00	44,090,188.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,000.00	5,455,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	18,959,725.00	26,737,926.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,042,919.00	691,520.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	231,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,016,000.00	10,263,760.00
210807	Газрын төлбөр	178,192.00	710,482.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,867,737,433.37	1,509,218,121.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,459,733,198.20	1,106,142,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	408,004,235.17	403,075,821.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	418,552,815.01	515,872,190.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,208,000.00	379,465,019.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,118,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	72,409,758.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмж	00.00	180,345,261.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	82,090,000.00	126,710,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	328,344,815.01	136,407,171.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	328,344,815.01	112,628,372.58
213405	Нэмэлт данснаас төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	23,778,799.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-66,719,972.98	744,667,005.74
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-66,719,972.98	744,667,005.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,162,898,409.00	5,113,876,474.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,879,800.00	43,767,169.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,879,800.00	43,767,169.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,879,800.00	43,767,169.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,879,800.00	43,767,169.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,150,018,609.00	5,070,109,305.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	196,151,309.00	376,615,005.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс до	27,898,239.00	93,239,783.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий бо	168,253,070.00	283,375,222.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,953,867,300.00	4,693,494,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байг	1,953,867,300.00	4,693,494,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,522,064,898.84	5,028,747,142.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,522,064,898.84	5,028,747,142.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,508,624,898.84	4,513,664,951.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	614,811,801.22	2,396,180,025.57
210101	Үндсэн цалин	374,572,116.40	1,156,898,237.17
210102	Нэмэгдэл	174,614,734.93	960,930,767.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,737,000.00	116,538,231.73
210104	Урамшуулал	24,882,599.89	122,093,306.44
210105	Гэрээт ажлын хөлс	13,005,350.00	39,719,483.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,158,968.61	285,936,623.81
210201	Тэтгэврийн даатгал	49,555,059.60	193,456,897.24
210202	Тэтгэмжийн даатгал	5,830,007.48	22,962,771.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,536,404.13	12,487,255.15
210204	Ажилгүйдлийн даатгал	1,130,568.40	9,998,671.90
210205	Эрүүл мэндийн даатгал	12,106,929.00	47,031,027.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,809,981.58	202,204,784.32
210301	Гэрэл, цахилгаан	15,479,782.58	34,261,505.31
210302	Түлш, халаалт	73,557,539.00	156,118,501.00
210303	Цэвэр, бохир ус	1,672,660.00	6,124,778.01
210304	Байрны түрээс	17,100,000.00	5,700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,787,958.93	203,556,523.10
210401	Бичиг хэрэг	8,813,100.00	31,313,267.00
210402	Тээвэр, шатахуун	35,625,500.00	100,471,178.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,888,845.93	21,485,391.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	340,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,120,513.00	49,746,687.00
2105	Нормативт зардал	2,181,381.00	4,355,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,181,381.00	4,355,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,564,850.00	233,678,459.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	260,000.00	66,970,100.00
210602	Тавилга	-	6,488,960.00
210604	Урсгал засвар	48,304,850.00	160,219,399.00
2107	Томилолт, зочны зардал	37,183,420.50	141,897,267.00
210701	Гадаад албан томилолт	1,460,340.00	2,849,280.00
210702	Дотоод албан томилолт	33,094,800.00	124,089,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,628,280.50	14,958,387.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам	31,381,336.00	43,889,040.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний тө	340,000.00	5,555,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	18,959,725.00	26,619,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,900,734.00	809,471.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	220,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,004,760.00	10,413,760.00
210807	Газрын төлбөр	154,117.00	270,834.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	529,745,201.00	1,001,966,728.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	529,745,201.00	1,001,966,728.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,440,000.00	515,082,190.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,440,000.00	378,675,019.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	72,409,758.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан ха	-	180,345,261.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,440,000.00	125,920,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, са	-	136,407,171.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	112,628,372.58
213405	Нэмэлт данснаас төвлөрүүлэх шилжүүлэг	-	23,778,799.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	640,833,510.16	85,129,332.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	32,761,700.00	80,270,332.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,761,700.00	80,270,332.00
2200	Дотоод эх үүсвэрээр	32,761,700.00	80,270,332.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	32,761,700.00	80,270,332.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(32,761,700.00)	(80,270,332.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	608,071,810.16	4,859,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	208,808.01	111,550.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	608,280,618.17	4,970,550.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	1,465,739,319.37	4,075,961,843.52
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,985,558.01)	(3,985,558.01)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	1,461,753,761.36	4,071,976,285.51
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	478,419,957.64	478,419,957.64
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	1,395,033,788.38	4,005,256,312.53
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	1,395,033,788.38	4,005,256,312.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	1,395,033,788.38	4,005,256,312.53
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	744,667,005.74	744,667,005.74
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	2,139,700,794.12	4,749,923,318.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,708,494,300.00	4,599,854,096.42	108,640,203.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,708,494,300.00	4,599,854,096.42	108,640,203.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,333,838,000.00	4,241,099,077.42	92,738,922.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,416,899,000.00	2,356,460,542.41	60,438,457.59
210101	Үндсэн цалин	1,205,238,100.00	1,156,898,237.17	48,339,862.83
210102	Нэмэгдэл	996,006,900.00	960,930,767.07	35,076,132.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	137,592,000.00	116,538,231.73	21,053,768.27
210104	Урамшуулал	78,062,000.00	122,093,306.44	-44,031,306.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шилжүүлэг	307,112,400.00	281,584,599.09	25,527,800.91
210201	Тэтгэврийн даатгал	208,836,400.00	190,667,661.24	18,168,738.76
210202	Тэтгэмжийн даатгал	24,569,000.00	22,556,341.75	2,012,658.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,284,500.00	12,246,519.83	37,980.17
210204	Ажилгүйдлийн даатгал	12,284,500.00	9,776,457.46	2,508,042.54
210205	Эрүүл мэндийн даатгал	49,138,000.00	46,337,618.81	2,800,381.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,524,700.00	202,204,784.32	1,319,915.68
210301	Гэрэл, цахилгаан	34,749,700.00	34,261,505.31	488,194.69
210302	Түлш, халаалт	158,075,000.00	156,118,501.00	1,956,499.00
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	6,124,778.01	(1,124,778.01)
210304	Байрны түрээс	5,700,000.00	5,700,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	182,858,500.00	182,792,379.10	66,120.90
210401	Бичиг хэрэг	25,500,300.00	25,496,000.00	4,300.00
210402	Тээвэр, шатахуун	89,164,300.00	89,156,578.00	7,722.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,494,200.00	21,485,391.10	8,808.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ус	584,800.00	540,000.00	44,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,114,900.00	46,114,410.00	490.00
2105	Нормативт зардал	4,357,500.00	4,355,500.00	2,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,357,500.00	4,355,500.00	2,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	244,211,200.00	244,202,537.00	8,663.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,103,500.00	28,103,500.00	-
210602	Тавилга	30,938,000.00	30,937,960.00	40.00
210604	Урсгал засвар	185,169,700.00	185,161,077.00	8,623.00
2107	Томилолт, зочны зардал	128,989,300.00	128,431,267.00	558,033.00
210701	Гадаад албан томилолт	3,000,000.00	2,849,280.00	150,720.00
210702	Дотоод албан томилолт	110,989,300.00	110,623,600.00	365,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	15,000,000.00	14,958,387.00	41,613.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тусламж	48,622,400.00	47,409,040.50	1,213,359.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	5,657,500.00	5,555,000.00	102,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	26,620,000.00	26,619,975.00	25.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,471,500.00	809,471.50	662,028.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	588,600.00	220,000.00	368,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,000,000.00	13,933,760.00	66,240.00
210807	Газрын төлбөр	284,800.00	270,834.00	13,966.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	797,263,000.00	793,658,428.00	3,604,572.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	797,263,000.00	793,658,428.00	3,604,572.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	374,656,300.00	358,755,019.00	15,901,281.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	374,656,300.00	358,755,019.00	15,901,281.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	72,414,800.00	72,409,758.00	5,042.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажил	180,350,000.00	180,345,261.00	4,739.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	121,891,500.00	106,000,000.00	15,891,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,708,494,300.00	4,599,854,096.42	108,640,203.58
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,693,494,300.00	4,580,865,927.42	112,628,372.58
132001	Орон нутгийн төсвөөс	4,693,494,300.00	4,580,865,927.42	112,628,372.58
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000.00	18,988,169.00	-3,988,169.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	18,988,169.00	-3,988,169.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	69.00	69.00	0.00
620001	Удирдах ажилтан	10.00	10.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	31.00	31.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	28.00	28.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	376,615,005.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	376,615,005.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	352,836,205.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,719,483.16
210105	Гэрээт ажлын хөлс	39,719,483.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,352,024.72
210201	Тэтгэврийн даатгал	2,789,236.00
210202	Тэтгэмжийн даатгал	406,429.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	240,735.32
210204	Ажилгүйдлийн даатгал	222,214.44
210205	Эрүүл мэндийн даатгал	693,409.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-
2104	Хангамж, бараа материалын зардал	20,764,144.00
210401	Бичиг хэрэг	5,817,267.00
210402	Тээвэр, шатахуун	11,314,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,632,277.00
2105	Нормативт зардал	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,226,254.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	58,628,500.00
210604	Урсгал засвар	7,597,754.00
2107	Томилолт, зочны зардал	13,466,000.00
210702	Дотоод албан томилолт	13,466,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	208,308,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	208,308,300.00
211	ХҮҮ	-
212	ТАТААС	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,778,799.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,778,799.12
213405	Нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлэх шилжүүлэг	23,778,799.12
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	376,615,005.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	376,615,005.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	93,239,783.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	283,375,222.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд аймгийн Засаг даргын тамгын газрыг “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нийтийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад засаг даргад туслах, хурал, засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах...” гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль /2024.01.12, 2024.04.19, 2024.06.05, 2024.07.10, 2024.12.03/
- Төрийн албаны тухай хууль /2024.06.05/
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /2024.01.12/
- Төрийн хэмнэлтийн тухай хууль /2024.01.17, 2024.12.12/
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /2024.01.12/

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлог тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 744,667.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
МӨНГӨН ХӨРӨНГӨ	111.6	4,970.6	4,859.0
АВЛАГА	35,247.7	2,633.7	(32,614.0)
УРЬДЧИЛГАА	-	-	-
БАРАА МАТЕРИАЛ	487,017.3	473,797.5	(13,219.7)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,482,879.8	4,268,521.6	785,641.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,005,256.3	4,749,923.3	744,667.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-	-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-	-
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	4,005,256.3	4,749,923.3	744,667.0
Хуримтлагдсан үр дүн	1,395,033.8	2,139,700.8	744,667.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,124,535.2	1,124,535.2	-
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,005,256.3	4,749,923.3	744,667.0

Дээрх хүснэгтээс харахад:

Мөнгөн хөрөнгө 4,970.6 мянган төгрөг болж 4,859.0 мянган төгрөгөөр өссөн нь ахмадын сангийн дансны үлдэгдэл байна.

Авлага 2,633.7 мянган төгрөг болж 32,614.0 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт төсвийн дансны үлдэгдлээс буцаан авах авлагыг барагдуулж, малчнаас 2,500.0 мянган төгрөг, нийгмийн даатгалаас 133.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

Бараа материал данс 473,797.5 мянган төгрөг болж 13,219.7 мянган төгрөгөөр буурсан нь мал, амьтадын хорогдол, бичиг хэрэгийн материалын үлдэгдэл багассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 4,268,521.6 мянган төгрөг болж 744,667.0 мянган төгрөгөөр өссөн нь 25,694.4 мянган төгрөгийн ланд крузер автомашиныг Батноров сумын ЗДТГ-аас, 199,000.0 мянган төгрөгийн ниссан патрул автомашиныг Мөрөн сумын ЗДТГ-аас, 349,461.1 мянган төгрөгийн ЗДТГ-ын автомашины шинэ зогсооллыг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгүүлж үнэ төлбөргүй орлогод авч, нэг цэгийн үйлчилгээний барилгын засварыг 114,000.0 мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн хөгжлийн төвийн контейнерыг 390,811.2 мянган төгрөгөөр, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг 88,843.6 мянган төгрөгөөр тус тус төсвийн хөрөнгөөр худалдан авч, 30,800.0 мянган төгрөгийн делика автомашиныг Цагдаагийн газарт үнэ төлбөргүй шилжүүлж, 201,369.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 6,487,440.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 2,020,345.8 мянган төгрөгөөр бууруулан, 4,467,094.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант хугацаанд төсвийн зардлыг 241,399.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,693,494.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 15,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 4,708,494.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 4,693,494.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 18,988.2 мянган төгрөгийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,599,854.1 мянган төгрөгийг зарцуулж, 108,640.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,599,854.1 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 89,134.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлыг 15,901.3 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна. Үүнд: цалингийн зардал 60,438.5 мянган төгрөг, НДШ-ийн зардал 25,527.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшууллын зардлыг 15,891.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,536,575.0	3,447,440.6	89,134.4	97.5
2	Биеийн тамирын уралдаан, тэмцэ	2,000.0	1,100.0	900.0	55.0
3	Уналга, цугларалт бэлтгэл сургуульлалт	90,500.0	90,344.4	155.6	99.8
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	374,656.3	358,755.0	15,901.3	95.8
5	Орон нутгийн нөөц хөрөнгө	600,000.0	597,451.0	2,549.0	99.6
6	Ахмадын сан	24,763.0	24,763.0	-	100.0
7	Улсын их баяр наадам	80,000.0	80,000.0	-	100.0
	НИЙТ	4,708,494.3	4,599,854.1	108,640.2	97.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан 93,239.8 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 283,375.2 мянган төгрөгийг бүрдүүлж, цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 39719.5 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 4,352.0 мянга, хангамж, бараа материалын зардалд 20,764.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 66,226.3 мянга, албан томилолтын зардалд 13,466.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 208,308.3 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 23,778.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Нэгдсэн судалгааны үр дүнгийн талаар

1. Ахмадын сангийн талаар:

Ахмадын сангийн 100180051501 дансны эхний үлдэгдэл 111.6 мянган төгрөг, тайлант онд 24,763.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, сангийн хөрөнгийг зохих журмын дагуу 19,920.0 мянган төгрөгийг зарцуулж, 4,954.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2. Худалдан авах ажиллагааны талаар:

Тус байгууллага нь 79,164.3 мянган төгрөгийн шатахуун худалдан авах ажиллагааг ХЭАЗДТГ/20240202001 дугаартай тендерийг зохион байгуулж, тендерт Питровис ХХК шалгарсан байна.

3. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн талаар:

Тус зардлын ангилалаас дараах арга хэмжээнд хөрөнгийг зарцуулсан байна. Үүнд:
Үндсэн үйл ажиллагааны зардалд 5,555.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

4. Бараа үйлчилгээний бусад зардлын талаар:

Тус зардлын ангилалаас дараах хөтөлбөр арга хэмжээнд хөрөнгийг зарцуулсан байна. Үүнд:

Биеийн тамир уралдаан тэмцээнийн зардлаас 1,100.0 мянган төгрөг, уналага, цугларалд бэлтгэл сургуулийн зардлаас 90,344.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны зардлаас 598,131.0 мянган төгрөг, ахмадын сангийн санхүүжилт 24,763.0 мянган төгрөг, улсын их баяр наадмын зардалд 80,000.0 мянган төгрөг, нийт 794338.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

5. Орон тооны талаар:

Тус байгууллага нь 2024 оны цалингийн зардалд 2,416,899.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 2,356,460.5 мянган төгрөгийг зарцуулж, 60,438.5 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Тус байгууллагад нийт 80 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 78 орон тоотой ажиллаж байна. Гүйцэтгэлээр төрийн захиргааны 2 орон тоо нөхөгдөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Энх-Амгалан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 9/195 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,745,591.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 57,455.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 43,091.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан байна.

Дээрх чиглэл, зааврыг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгадагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад тайлант онд завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 30,877.8 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 албан шаардлага, 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	10,000.0	1	10,000.0	100
Албан шаардлага	1	20,877.8	1	20,877.8	100
Зөвлөмж					
Нийт дүн	2	30,877.8	2	30,877.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудалд байгууллагын бараа материалын анхан шатны баримт, зарцуулалт, шатахууны норм баримталж буй эсэх, орон нутгийн нөөц хөрөнгийн зарцуулалт, түүний анхан шатны шийдвэрийн талаар авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 284,613.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 5 төсөл арга хэмжээний 284,613.7 мянган төгрөгийн зураг төсвийг бараа материалд орлогоор бүртгэснийг залруулсан.

Аудитаар 30,845.0 мянган төгрөгийн зөрчил² илэрч 18,034.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 12,810.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлагыг хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас 18,034.5 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй, төсөвт төвлөрүүлээгүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1."энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Жилийн эцэст нэр бүхий 13 ажилтанд сарын цалинг 1-1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 12,810.2 мянган төгрөгөөр шагнасан нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3.3, мөн мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалд хамааралгүй хөрөнгө бүртгэсэн	1	284,613.7			1	284,613.7	1	284,613.7				
Дүн	1	284,613.7			1	284,613.7	1	284,613.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Урамшууллаас ХХОАТ суутгаагүй	1	18,034.5	1	18,034.5								
Хангалтгүй үндэслэлээр шагнал олгож үр ашиггүй хөрөнгө зарцуулсан	1	12,810.5			1	12,810.5						
Дүн	2	30,845.0	1	18,034.5	1	12,810.5						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
								-
Дүн								-
Нийт дүн								-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 25

Дугаар 148-ХЭА-2025/157/НА-СТА-ТШЗ
А 2360453
Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст нэр бүхий 13 ажилтанд сарын цалинг 1-1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр буюу 12,810.5 мянган төгрөгөөр шагнаж улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулсан нь хууль, журам, тогтоолд нийцэхгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх "Улирлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 3.3. "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно...", 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урамшуулал давхардуулан олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Жаргалсайхан, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Д.ОЮУНТУЯА

Г.ЭНХ-АМГАЛАН

232540148

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 119-ХЭА-2025/157/НА-СТА-ТШЗ
А 2360453 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас 18,034.5 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1. "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх," гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй," гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй татварын 18,034.5 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Жаргалсайхан, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Д.ОЮУНТУЯА
Г.ЭНХ-АМГАЛАН

232550119